



**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 07 -ны өдөр

Дугаар А/40

Эрдэнэт

**“Зөв гэр бүл-Зөв дадал” цахим  
уралдаан зарлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн гэр бүлийн өдрийг угтан эрүүл мэндийн газрын албан хаагчдын гэр бүлд эрүүл, амьдралын зөв дадлыг хэвшүүлэх, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор “Зөв гэр бүл-Зөв дадал” цахим уралдааныг зохион байгуулсугай.

2. “Зөв гэр бүл-Зөв дадал” цахим уралдааны удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, үйл ажиллганы төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, төсвийн тооцооллыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Уралдааныг амжилттай зохион байгуулж, үр дүнг тооцон танилцуулахыг Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал урамшуулал хариуцсан мэргэжилтэн /С.Мөнхзул/, Халдварт бус өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн /Н.Мөнгөнцацралт/ нарт үүрэг болгосугай.

4. Шаардлагатай төсөв болох 75.000 /Далан таван мянган төгрөг/-н төсөл хөтөлбөрийн бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан / Н.Чулуун-Эрдэнэ/- д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн / Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

My doc. EMG-iin dargiin tushaal



**“ЗӨВ ГЭР БҮЛ-ЗӨВ ДАДАЛ” ЦАХИМ  
УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

**Үндэслэл**

НҮБ-ын ерөнхий ассамблей 1993 оны есдүгээр сарын 20-ны хуралдаанаар 1994 оноос эхлэн тавдугаар сарын 15 өдрийг "Гэр бүлийн өдөр" болгох тогтоол баталсан байдаг. Улс үндэстэн энх тайван оршин тогтнох хамгийн бага нэгжүүдийн нэг бол гэр бүл гэж үздэг. Гэр бүлийн сайн сайхан ирээдүй тухайн улс орны хувьд хамгийн чухал үнэт зүйл юм. Дэлхийн гэр бүлийн өдрийг тэмдэглэж өнгөрүүлснээс хойш өдгөө 21 жил болж байгаа бөгөөд Монгол улсын хувьд энэхүү өдрийг энэ жил арав дахь удаагаа тэмдэглэж байна.

Амьдралын буруу хэвшил, хорт зуршлаас шалтгаалсан өвчлөл манай улсын хүн амын дунд жил ирэх тусам өсөн нэмэгдэж байна. Архи, тамхины зохисгүй хэрэглээ, буруу хооллолт, хөдөлгөөний дутагдлаас шалтгаалсан халдварт бус өвчин нас баралтын 80 гаруй хувийг эзэлж байна. Ялангуяа цусны даралт ихсэх өвчин, чихрийн шижин, элэгний өвчин, хорт хавдар зэрэг эрүүл амьдралын хэв маяг алдагдсанаас үүдсэн өвчлөл ихсэж байна.

**Зорилго:**

Дэлхийн гэр бүлийн өдрийг угтан эрүүл мэндийн газрын албан хаагчдын гэр бүлд эрүүл, амьдралын зөв дадлыг хэвшүүлэх, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх

**Зорилт:**

- 1.Архины хэрэглээнээс татгалзах
- 2.Тамхины хэрэглээнээс татгалзах
- 3.Дасгал хөдөлгөөн хийх
- 4.Зөв хооллох

**Хамрах хүрээ:** Эрүүл мэндийн газрын албан хаагчид гэр бүлийн хамт.

**Хугацаа:** 2020 оны 05 дугаар сарын 6-ны өдрөөс 15-ны өдөр хүртэл

**Хийгдэх ажил:**

- 1.Дээрх 4 зорилтын хүрээнд өөрийн гэр бүлийн эрүүл зөв дадлыг бусад гэр бүлүүдэд уриалах, туршлага солилцох ЭМГ-ын /хаалттай/ FACEBOOK группэд нийтлэх, лайк даруулж, сэтгэгдлийг нь үлдээх, санал хүсэлтийг сонсох.
- 2.Эрүүл мэндийн газрын ажилчдын цусны даралт ихсэх өвчнөөс сэргийлж даралтыг хэмжих аппараттай болох
- 3.Амьдралын буруу хэвшил, хорт зуршлаас гарах сөрөг үр дагавар, хор хөнөөлийн талаар сургалт, сурталчилгаа хийх.

4.Идэвхи, санаачилгатай оролцож байгаа 1 албан хаагчийн гэр бүлийг УЗХ-аар хэлэлцүүлэн “ЗӨВ ГЭР БҮЛ-ЗӨВ ДАДАЛ”-өргөмжлөлөөр шалгаруулж, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулах.

Шалгарсан албан хаагчийн гэр бүлд дараах шагнал, урамшууллыг олгоно.

1. Өргөмжлөл
2. ЭМГ-ын даргын 1 өдрийн цалинтай чөлөө олгох эрхийн бичиг
3. Гэр бүлийн зураг


АМЖИЛТ ХҮСЬЕ!

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:ЭМАНАШУХМ  С.МӨНХЗУЛ

ХБӨТСХМ

Н. МӨНГӨНЦАЦРАЛТ

ЭМГ-ын даргын 2020 оны 05 сарын 07. -ны  
өдрийн 14/0 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Цахим уралдааны удирдамж, төлөвлөгөө батлуулах	05 сарын 06	ЭМАНАШУХМ С.Мөнхзул ХБӨТСХМ Н.Мөнгөнцацралт
2	Цахим уралдаанд ирсэн уриалгуудыг цахимд байршуулах	05 сарын 06-14	ЭМАНАШУХМ С.Мөнхзул ХБӨТСХМ Н.Мөнгөнцацралт
3	Амьдралын буруу хэвшил, хорт зуршлаас гарах сөрөг үр дагавар, хор хөнөөлийн талаар сургалт, сурталчилгаа хийж албан хаагчид болон тэдний гэр бүлийхэнд цахимаар түгээх	05 сарын 07-15	ЭМАНАШУХМ С.Мөнхзул ХБӨТСХМ Н.Мөнгөнцацралт НБТЧОГХМ Ө.Билэгсайхан ХТХАБАХМ Т.Байгаль
4	"Зөв хоололтыг гэр бүийн гишүүн бүрт" сэдэвт сургалт	05 сарын 11	ХТХАБАХМ Т.Байгаль
5	Цахим уралдааныг дүгнэх	05 сарын 15	ЭМАНАШУХМ С.Мөнхзул ХБӨТСХМ Н.Мөнгөнцацралт
6	Шагналыг гардуулах	05 сарын 15	Дарга Ц.Мөнхцэцэг

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН: ЭМАНАШУХМ *С.Мөнхзул* С.МӨНХЗУЛ

ХБӨТСХМ

Н. МӨНГӨНЦАЦРАЛТ